



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2028 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 1/29

Мандалговь

“Засаг даргын тамгын газрын барилгын засвар  
/Дундговь, Дэлгэрцогт сум/” ажлын гүйцэтгэгчийг  
сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Засаг даргын тамгын газрын барилгын засвар /Дундговь, Дэлгэрцогт сум/-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Түвшинжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд: Б.Мижиддорж (Иргэний төлөөлөл)  
Э.Дүүрэнжаргал (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)  
Б.Төвшинжаргал (Онцгой байдлын газрын нягтлан бодогч)

Нарийн бичиг: М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн Газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Н.Түвшинжаргал)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ



4322159069